



HAL
open science

Jamiyan-Ombo Gantulga, Chimiddorj Yeruul-Erdene, Jérôme Magail, Yury
Esin

► **To cite this version:**

Jamiyan-Ombo Gantulga, Chimiddorj Yeruul-Erdene, Jérôme Magail, Yury Esin.
. STUDIA ARCHAEOLOGICA INSTITUTI ARCHAEOLOGICI
ACADEMIAE SCIENTIARUM MONGOLICAE, 2013, Tome XXXIII (Fascicule 6), pp.95-119. hal-
02366980

HAL Id: hal-02366980

<https://hal.science/hal-02366980v1>

Submitted on 17 Nov 2019

HAL is a multi-disciplinary open access archive for the deposit and dissemination of scientific research documents, whether they are published or not. The documents may come from teaching and research institutions in France or abroad, or from public or private research centers.

L'archive ouverte pluridisciplinaire **HAL**, est destinée au dépôt et à la diffusion de documents scientifiques de niveau recherche, publiés ou non, émanant des établissements d'enseignement et de recherche français ou étrangers, des laboratoires publics ou privés.

Ж.Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ,
Ж.Магай¹, Ю.Н.Есин²

ХОЙД ТАМИРЫН ХӨНДИЙ ДЭХ БУГАН ЧУЛУУН ХӨШӨӨНИЙ СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮН

Удиртгал

Евразийн хээр талын бүс нутагт өргөн тархсан хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн түүх соёлын гайхамшигт дурсгал болох буган хөшөөг эрдэмтэд зуу гаруй жилийн тэртээгээс судалж эхэлсэн түүхтэй.

Энэ хугацаанд олсон амжилт багагүй бөгөөд эдгээрийн нэг нь ерөнхийдөө үгүй болсон баатарлаг өвөг дээдэст зориулсан тахил тайлгын зориулалттай дурсгал болохыг тодруулсан явдал юм. Гэхдээ уг дурсгал дахь бүтээгсдийн оюун сэтгэлгээний гол түлхүүр болох бугыг олон зүйлийн ан амьтдаас сонгох болсон утга бэлгэдлийн гол асуудал тайлагдаагүй хэвээр байна.

Бид энэ удаад Хойд Тамирын голын сав нутагт Монгол-Монакогийн хамтарсан археологийн экспедицийн хүрээнд хийж буй буган хөшөөний судалгааны зарим үр дүн буюу хөшөөдийн байршил, хэмжээ, хөшөөн дээрх зарим сонирхолтой дүрслэлийн талаархи судалгаа, хөшөөг хэрхэн урлаж, босгож байсан арга хийгээд буган хөшөөний чулууг олзворлож байсан газар, чулууг хэрхэн тээвэрлэж байсан тухай таамаглал, буган хөшөөнд холбогдох тахилын байгууламж, түүний учир холбогдол, он цаг тогтоох судалгааны үр дүн зэргийг нийтэлж байна.

Хойд Тамирын голын хөндийн буган хөшөө

Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний анги 2006 оноос эхлэн Архангай аймгийн Их Тамир, Батцэнгэл сумдын нутаг Хойд Тамирын голын сав нутагт суурин судалгаа хийж байгаа билээ. Хамтарсан судалгааны ажлын нэг үндсэн чиглэл бол буга хөшөөний судалгаа юм.

Хойд Тамирын голын хөндийд 100 гаруй буган хөшөө бүртгэн тэмдэглэсэн нь одоогоор нэг голын сав нутагт хамгийн олон тоотой байгаа тохиолдол болох юм (Зураг 1). Энэ нь Хойд Тамирын голын хөндий нь буган хөшөөний соёлын нэгэн том төв байсныг харуулж байна.

¹ Монако улсын Нэн эртний хүн судлалын музейн судлаач, доктор

² ОХУ-ын Хакасын БНУ-ын Хэл зохиол, Түүхийн хүрээлэнгийн Археологийн тасгийн эрхлэгч, доктор

Бид буган хөшөөдийг илрүүлэн тэмдэглэж судлахаас гадна энэхүү дурсгалын хэрхэн цоглоож байсныг тодруулах зарим туршилт судалгааг хийж байгаа билээ. Үүнд, буган хөшөө хийх чулууг олзворлож байсан газрыг тогтоох, хөшөөг суурилуулсан байдал, урлаж байсан арга зэргийг тодруулах судалгаа багтана.

Хөшөөдийн байршил ба хэмжээ

Буган хөшөө нь нас барсан өвөг дээдсийн дурсгалд зориулсан дурсгал тул зөвхөн хөшөө төдийгүй түүний ойр орших тахилын байгууламжийн судалгааг зайлшгүй анхааран судлах шаардлагатай.

Бидний судалгаанд хамрагдсан 22 газарт буй буган хөшөөд нь: *Нэгдүгээрт*, анхны байрлалаараа, *Хоёрдугаарт*, анхны байрлалаа алдсан, *Гуравдугаарт*, хожим өөр зориулалтаар дахин ашигласан байдалтайгаар оршино. Тухайлбал, буган хөшөөг дөрвөлжин булшны хана, нүхний таг болгон ашигласан байдаг бол Түрэгийн үед тахилын онгоны хашлага чулуу мөн хүн чулуу зэргийг хийсэн байдаг харин орчин үед булшны хөшөө чулуу болгон ашиглаж түүний хэлбэр төрх, уран нарийн сийлбэрийг эвдэн сүйтгэсэн нь олонтоо тохиолдож байна (*Зураг 2*).

Эдгээрээс 2, 3-р тохиолдлыг Алтансаңдал уул (Доржсүрэн, 1957, 49-50; Баяр, 1997, 83-84, 96-97), Булганы Хайрхан хөндий, Өвөрхангайн Тэмээн чулуу, Архангайн Шивэртийн ам, Цацын эрэг, Баянцагааны хөндий (Войтов, 1996, 22, 52), Хойд Тамирын голын хөндийн Хор хадны ам, Гэндэн толгойн урд энгэр (Ерөөл-Эрдэнэ нар, 2012, 8-10) зэрэг газрын хөшөөдөөс харж болно.

Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөөд нь 44-408 см хүртэлх өндөртэй (*Зураг 3*) бөгөөд тэдгээрийг улаан хүрэн, хөх саарал өнгийн боржин, хөхөвтөр өнгийн элсэн чулуугаар хийж, сийлбэрийг 0.5-1 см гүнтэйгээр маш нарийн уртай хийжээ.

Хөшөөн дээрх зарим дүрслэл

Хойд Тамирын голын буган хөшөөд нь дүр, дүрслэлийн хувьд Монгол-Өвөр Байгалийн хэлбэр төрхт (Волков, 2002, 13-25; Цэвээндорж нар, 2002, 101-107) хөшөөний ангилалд хамаарна. Ийм хэлбэр төрхийн буган хөшөөд тооны хувьд хамгийн олон байдаг бөгөөд гол шигүү тархсан бүс нутаг нь Хангайн бүс нутаг тэр дундаа Хойд Тамирын голын сав нутаг юм.

Буган хөшөөн дээрх дүрслэлийн талаарх судалгаа чамгүй хийгдсэн хэдий ч тэдгээрийн учир холбогдол, бэлгэдлийн талаар судлаачид харилцан адилгүй байр суурьтай байдаг. Ерөнхийдөө хөшөөн дээрх сийлбэр нь оройн хэсэг, дунд хэсэг, доод хэсэг гэсэн үндсэн гурван бүлэг дүрслэлээс бүрддэг. Эдгээр бүлэг дүрслэлүүдэд хүн, хүний нүүр, тэнгэр эрхэс, гоёл чимэглэл, эд зүйлс, зэр зэвсгийн зүйлс зэрэг багтана (*Зураг 4*).

Бид энэ удаад зарим нэг дүрслэлийн талаар өөрсдийн саналыг дэвшүүлэхийн зэрэгцээ анх удаа олдож буй хүний дүрслэл болон

гүйвэр³ хэмээх зэвсгийн талаар тодруулан өгүүлнэ.

Хүний дүрслэл. Хоёр хүний дүр бүхий энэхүү буган хөшөө нь Улаан толгойн баруун бэлд орших дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн баруун урд талд тахилын байгууламжуудын хамт байрлах ба 87-р хөшөө хэмээн дугаарласан болно (Зураг 5). Хөшөөн дээрх хүний дүрээс бусад нь буган хөшөөнд түгээмэл дүрслэгддэг буга, янгир, зэр зэвсгийн дүрслэлүүд юм.

Хөшөөний өргөн талын зүүн доод хэсэгт тулалдаж буй хоёр хүнийг эсрэг (дээш, доош) харуулан урлажээ.

Шил рүүгээ унжсан сэртгэр бүхий малгай (дуулга?)-тай, нэг гараа сул орхиж нөгөө гартаа үзүүр хэсэгтээ том бөмбөлөг бүхий бүдүүн иштэй зэвсэг барин довтолж буй хүнийг доош харуулан дүрсэлжээ. Түүний эсрэг талд толгойдоо бүрх мэт малгайтай (?), нуруундаа ямар нэг зүйл үүрч, хагас суусан дайчныг дүрслэсэн ба тэрээр хоёр гараараа нөгөө хүний цохиж байгаа зүйлээс хамгаалж буй байдалтай ажээ.

Дээрх дайчны барьсан зэвсэг нь доор өгүүлэх 41-р буган хөшөөнөө бодит байдлаар дүрслэсэн гүйвэр хэмээх зэвсэгтэй ихээхэн төстэй юм.

Монгол нутгаас ийм төрлийн зэвсэг биетээр олдож байгаагүй боловч хүрэл, төмрийн түрүү үеийн хадны зурагт гүйвэрийн төрөл болох бялуу⁴ хэмээх зэвсэг цөөнгүй тохиолддог. Тухайлбал, Монгол Алтайн Цагаан Салаа, Бага Ойгорын хадны зургуудад нум сумтай анчин бүснээсээ зүүсэн, эсвэл гартаа бариад зогсож байгаа эсвэл ан амьтныг цохиж агнаж байгаагаар дүрслэсэн байдаг (Jacobson et al., 2001, fig. 89, 161, fig. 365, 225, fig. 722, 318, fig. 783, 332, fig. 793, 336, fig. 860, 353, fig. 1272, 465).

Зэр зэвсгийн дүрслэл. Хойд Тамирын голын хөшөөдөд буган хөшөөнөө нийтлэг дүрслэгддэг зэр зэвсгийн зүйлс буйгаас гадна шинэ төрлийн зэвсгийн дүрслэл олдсон нь сонирхолтой.

Буган хөшөөдөд дүрслэгдсэн зэр зэвсгийн зүйлсийг доорхи байдлаар ангилан үзэж болно. Үүнд:

Довтолгооны зэвсэг

Алсын тусгалтай зэвсэг - Нум сум

Ойрын зайн зэвсэг - Чинжаал, хутга, зээтүү, сүх, ооль, гүйвэр

Хамгаалалтын хэрэгсэл

Бамбай

Бусад дагалдах хэрэгсэл

Саадаг, дэгээ, гох, агсрага бүс зэрэг зүйлс болно.

Довтолгооны зэвсэг. Судалгаанд хамрагдсан 98 хөшөөнд алсын тусгалтай зэвсэг болох нум сум 17 удаа, хутга, чинжаал 50 удаа, байлдааны зээтүү, сүх 31 удаа, гүйвэр 2 тус тус дүрслэгдсэн байна.

Гүйвэр. Хавцалынамны 41-р буган хөшөөнөө энэхүү зэвсэг дүрслэгдсэнийг энэ жил илрүүлэн олсон билээ. Ийм зэвсэг буган хөшөөнөө дүрслэгдсэн

³ Тайлбар толиудад “Урт охор хоёр модны хооронд гархи хэлхэн шалам хадаж сажин жанчихуйг нь Гүйвэр (гүйвйр) хэмээмүй” (Сумъяабаатар, 2005, 272) мөн “Чулуу зэрэг бөөрөнхийтэр зүйлийг үсэргэн шидэх зэвсэг, дүүгүүр” (Монгол хэлний..., 2008, А-Г, 565) гэх зэргээр тайлбарлажээ. Иймээс бид дээрх тайлбаруудыг үндэслэн Гүйвэр хэмээх нэрийг хэрэглэв.

⁴ Аливаа цохих шийдамлах модыг Бялуу хэмээмүй (Сумъяабаатар, 2005, 272) мөн “Шийдэм цохих шийдэмлэх модон зэвсэг, бороохой: бялуу шийдэм (цохих, жанчих модон зэвсэг)” (Монгол хэлний..., 2008, Б-Г, 431) хэмээн тайлбарласан байна. Бялууны цохилуур түрүү нь том бонхгор агаад түүний гадарга нь гөлгөр, эсвэл өргөс, шүдтэй бөөрөнхий, зууван, гурвалжин, дөрвөлжин янз бүрийн хэлбэртэй байна (Базарсүрэн, 2006, 107).

нь урьд өмнө тохиолдож байгаагүй юм.

Энэхүү зэвсэг нь урт иштэй, гурван шовх өргөстэй бөмбөлөг хэлбэрт цохилуур, тэдгээрийг холбосон холбоос зэргээс бүрдэнэ. Хөшөөнөө дүрслэгдсэн зэвсгийн хэмжээг тодорхойлвол, иш нь 75 см урт, суурь хэсэгтээ 5 см, үзүүр хэсгээрээ 2.5 см орчим бүдүүн. Цохилуур нь 7 см голчтой ба гурван талдаа 2-3 см урт шовх өргөстэй. Иш, цохилуур хоёрыг 1 см орчим бүдүүн 20 см урт зүйлээр холбожээ (*Зураг 7*).

Гүйвэр зэвсгийг Сяньби, Тоба болон Эртний Хятадын Хан улсын цэрэгт (Бобров, Худяков, 2005, 117-118), мөн хожим VIII-X зууны үед Зүүн Европын нүүдэлчид (Крыганов, 1987), X-XIV зууны үед Монголын армид (Горелик, 2002, 20), XIII зууны үед Баруун Европт (Stone, LaRocca, 1999) өргөнөөр хэрэглэж байсныг дурдсан байдаг. Ийнхүү түүхийн урт удаан хугацааны турш олон газар оронд ашиглаж байсан гүйвэрийн ишийг мод, ясаар, харин цохилуурыг олон янзын хэлбэр төрхтэйгээр, төрөл бүрийн материалаар хийж сур, олс, гинж зэргээр холбож бүтээдэг байжээ.

Хүннүгийн зэр зэвсгийн зүйлс дотор ийм төрлийн зэвсэг тохиолдож байгаагүй боловч гүйвэрийн цохилуур бөмбөлөгтэй адил голыг нь нүхлэсэн хүрэл бөмбөлөг хэлбэртэй зэвсгийг Гол модны язгууртны 20-р булшнаас 2005 онд илрүүлэн олсон юм (*Зураг 8*).

Гүйвэрийг буган хөшөөнөө бодитоор дүрсэлсэн байгаа нь уг зэвсгийг Монгол нутаг дахь эртний нүүдэлчид хүрэл зэвсгийн сүүд үеэс хэрэглэж байсны баримт болох юм.

Хамгаалалтын хэрэгсэл. Хамгаалалтын хэрэгсэл болох таван талт бамбай (Цэвээндорж, 1976, 53-57; 2003, 48-52) 98 буган хөшөөнөө 42 удаа тохиолдож байна. Бамбайг дөрвөлжин болон таван талт хэлбэртэйгээр дүрслэн үзүүлжээ. Дөрвөлжин хэлбэртэй бамбайг дан тагнай болон голоороо нарийн зураас бүхий тагнай хээгээр, таван талт бамбайг дан тагнай, голоороо нарийн зураас бүхий тагнай, дээрээ болон дунд хэсэгтээ дугуй чимэглэл бүхий тагнай, ташуу хөндлөн зураас бүхий тагнай хээгээр чимэглэсэн байна (*Зураг 9*).

2.3. Чулуу олзворлож байсан газар ба тээвэрлэлт

Монгол-Монакогийн хамтарсан судалгааны анги Баянцагааны хөндийн адаг, Шивэртийн аманд орших хойноос урагш сунаж тогтсон жалганаас буган хөшөөний чулуу олзворлож байсан газрыг илрүүлэн олсон юм.

Тэнд Хойд Тамирын голын хөндий болон Баянцагааны хөндийд буй буган хөшөөдийг урласантай ижил давхарлаж үелэсэн боржин чулуун тогтоцтой. Тэдгээр үелэн тогтсон чулуудыг салган хөшөө хийхэд бэлэн болгосон нь ч бий. Жалганы баруун урд эрэг дээр тэдгээр боржин чулуудаар хийсэн буган хөшөөд, хиргисүүр болон тахилын байгууламжууд ч олон. Энэ нь ойр орчимд байх буган хөшөөдийн үндсэн материал болох цайвар боржин чулуут төдий л холгүй газраас олзворлож байсныг гэрчилж буй хэрэг юм.

Чулууашиглан бүтээсэн дурсгалууд, тэр дундаа чулуун хөшөөг бүтээхдээ үндсэн материал болох чулуугаа хаанаас, хэрхэн олзворлож байсан тухай асуудлыг нарийвчлан судалсан нь хомс байна. Энэ нь аливаа дурсгалт газрын

судалгааны салшгүй нэг хэсэг мөн тул бид цаашид чулуулгын бүтцийг тодорхойлох судалгаа, зарим сорилтын малтлага хийхээр төлөвлөж байна (Ерөөл-Эрдэнэ нар, 2007, 131-140).

Энэхүү чулуу олзворлох газраас авсан чулууг хамгийн ойр нь 100 метр ба түүнээс ч хол зайд тээвэрлэн аваачиж буган хөшөөдийг урлан босгосон байна. Энэ хол зайд чулууг (50 кг - 5 тн орчим) хэрхэн зөөж тээвэрлэж байв? гэсэн асуулт зайлшгүй урган гардаг. Энэ асуултанд баттай хариулт болохуйц баримт үгүй ч дараах байдлаар таамаглан төсөөлж болох мэт санагдана.

Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед тэрэг хэрэглэж байсныг хадны зургийн дүрслэлээс бид мэдэх билээ. Тухайн үед нэгэнт тэрэг хэрэглэх болсон тул хөшүүргийн болон тусгайлан бэлтгэсэн шургааг модон дээгүүр гулсуулан тээвэрлэх зэрэг аргуудыг хэрэглэж байсан нь эргэлзээгүй.

Иймээс тухайн үед чарга, тэргийг ашиглан харьцангуй бага жинтэй чулууг тээвэрлэн зөөж байсан хэмээн төсөөлж болох юм. Харин том буюу хүнд жинтэй чулууг шургааг дээгүүр гулсуулж зөөхөөс гадна өвлийн улиралд тээвэрлэж байсан байх магадлалтай. Тодруулбал, хүйтний улиралд тусгайлан дагтаршуулан зассан (мөсөн) замаар* бэлдсэн том чулуугаа гулсуулах аргаар тээвэрлэн босгох газартаа аваачдаг байсан болов уу хэмээн таамаглаж болмоор санагдана.

Үүнээс гадна буган хөшөөн дээр зосон будгийн үлдэгдэл ажиглагдсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү буган хөшөө Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Хойд Тамирын голын урд эрэг, Шивэртийн аманд орших ба 68-р хөшөө хэмээн дугаарласан болно. Зосон будгийн үлдэгдэл уг хөшөөний нэг өргөн талын хэсэгхэн газарт мэдэгдэх ба хөшөөн дээрх дүрсийг зосон будгаар зурсаны дараа сийлсэн эсвэл дүрсийг сийлсэний дараа зосоор будсан байж болох юм. Эсвэл бүр тахил тайлгын зан үйлтэй ч холбоотой байж болохыг үгүйсгэх аргагүй юм. Гэхдээ энэ нь зөвхөн ажиглалтаас үүдсэн таамаг төдий зүйл бөгөөд цаашид нарийвчлан судлах шаардлагатай юм.

Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн хадны зурагт буган хөшөөнөө нийтлэг тохиолддогтой ижилсэх зарим дүрслэл буйг Хөрөөгийн үзүүрийн хадны зургаар жишээ болгон дурдаж болно (Ерөөл-Эрдэнэ нар, 2007, 131-140). Буган хөшөөн дээрх дүрслэл нь үйлдсэн арга барилын хувьд хадны зургийн бүх талбайгаар нь хонхойлон цохих (сийлэх) аргатай үндсэндээ ижил юм. Судлаачид хадны зургийг урлахдаа ямар нэг төмөрлөг багаж юмуу чулуу ашиглаж байсан хэмээн таамагладаг (Батболд, 2011, 58-59).

Бид 2010 онд буган хөшөөн дэх дүрсийг хэрхэн урлаж байсныг тодруулах туршиц судалгааг хийсэн бөгөөд Францын судлаач, чулууны сийлбэрч Э.Борго Баянцагааны хөндийгөөс хөшөө хийх боломжтой чулууг сонгон авч төмөрлөг багаж болон ердийн үзүүртэй чулуугаар урлаж үзэхэд хөшөөний гадаргуу дээр чулуугаар холтчин цохиж урлах нь илүү тохиромжтой болохыг тогтоосон юм (Зураг 10). Үүнээс гадна Францын судлаач С.Салисис Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн хажуугаас зураг, сийлбэр хийх боломжтой чулуун багаж олсон нь дээрх таамаглалуудыг батлаж байна (Зураг 11).

Хөшөөг хэрхэн босгон байрлуулж байсан үйл явцыг бүхэлд нь нэхэн сэргээх боломжгүй ч туршиц судалгааны хүрээнд хийсэн малтлагаас үзвэл гүехэн нүхэнд суурилуулдаг байсныг мэдэж болохоор байна. Тухайлбал, 2009 онд хийсэн 32-р буган хөшөөний малтлагаас үзвэл 302 см өндөртэй буган хөшөөг 32 см гүн нүхэнд суурилуулсан байв (Гантулга нар, 2011, 19).

3. Тахилын байгууламж

Буган хөшөөний тахилын цогцолбор үндсэндээ гурван янзын байдалтай оршино. Үүнд: *Нэгдүгээрт*, буган хөшөө нь өргөн талбайг эзлэсэн дөрвөлжиндүү хэлбэртэй, овгор чулуун байгууламжийн дунд болон захад байрлах ба цагариг хэлбэрийн тахилын байгууламжууд гадуур нь хүрээлсэн байдлаар оршино. *Хоёрдугаарт*, буган хөшөө нь ганц нэгээс авхуулан хэдэн арваараа цувран байрлах ба овгор чулуун дараастай болон цагариг хэлбэрийн чулуун дарааст тахилын байгууламжуудын голд. *Гуравдугаарт*, буган хөшөө нь дөрвөлжин хашлага чулууны голд байрлана.

Нэгдүгээр буюу том хэмжээний тахилын цогцолборуудаас Хануйн хөндийн Жаргалантын ам (Волков, 1981; 2001; Төрбат нар, 2011) (*Зураг 12*), Завханы Шилүүстэйн Дааган дэл (Granö, 1912; Волков, 1981; 2001), Хөвсгөлийн Бүрэнтогтохын Уушгийн өвөр, Цагаан-Уул сумын Хөшөөт (Волков, 1981; 2001) зэрэг газрыг нэрлэж болно. Харин хоёрдугаар хэлбэрийн тахилын байгууламж бүхий буган хөшөөд Архангайн Их Тамир сумын Шивэртийн ам, Цацын эрэг, Баянцагааны хөндий, Хавцалын ам, Улаан толгойн ар шил (Волков, 2001; Ерөөл-Эрдэнэ нар, 2011), Булганы Сайхан сумын Хайрханы хөндий (*Зураг 13*), Орхон сумын төвийн ойролцоо, Хөвсгөлийн Бүрэнтогтохын Зуны гол, Галтын 3-р баг, Нүхтийн ам, Шинэ-Идэрийн Дөрвөлжин ам (Волков, 1981; 2001) зэрэг газруудад бий. Гуравдугаар тохиолдлыг Хойд Тамирын голын Элстэйн голын ам (*Зураг 14*), Шивэртийн ам (Гантулга нар, 2011; Ерөөл-Эрдэнэ нар, 2012), Хөвсгөлийн Жаргалант сумын Тээл (Fitzhugh, 2009, 56) зэрэг газрын буган хөшөөдөөс харж болно.

Хойд Тамирын голын сав нутагт дахь буган хөшөөд нь зууван хэлбэрийн овгор чулуун дарааст, цагариг хэлбэрийн чулуун дарааст гэсэн хоёр өөр хэлбэрийн тахилын байгууламжтай (*Хүснэгт 1, Зураг 15-19*).

Зууван хэлбэрийн овгор чулуун дарааст тахилын байгууламж. Ийм хэлбэр төрхийн тахилын байгууламж буган хөшөөний зүүн талд нэг болон хэд хэдэн эгнээнд цувран байрладаг. Цөөн тохиолдолд Ази-Европын амьтны дүрслэлгүй буган хөшөөнөө тохиолддог. Мөн I хэлбэрийн тахилын байгууламж Хануйн хөндийн Жаргалантын аманд зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон 9 бүлэг нийт 830 гаруй буй бөгөөд эдгээрийн 670 орчим нь буган хөшөөний төв тахилгын чуулбарт хамаарна. Энэхүү том чуулбарын урд болон ар талд тус бүр дөрвөн бүлэг нийт 260 орчим I хэлбэрийн тахилын байгууламж бий (Баярсайхан, 2011, 112-113).

Хойд Тамирын голын хөндий дэх буган хөшөөний ийм хэлбэрийн тахилын байгууламжийн чулуун дараасыг хоёр өөр байдлаар хийсэн нь судалгааны явцад ажиглагдаж байна. Үүнд: *Нэгд*, Гонзгой том чулуудыг

цагариг хэлбэрээр хүрээлж түүний голд жижиг чулуун овгор дараас хийсэн (38-р буган хөшөөний 27-р тахилын байгууламж), Хоёрт, Нэгэн жигд жижиг чулуугаар зууван хэлбэрийн овгор дараас хийж байгуулсан (38-р буган хөшөөний 1, 62-р буган хөшөөний 1-р тахилын байгууламж) зэрэг болно. Эдгээр тахилын байгууламжийн чулуун дараасны голч нь 200-300 см гаруй, өндөр нь дунджаар 50 см, зарим тохиолдолд намхан тэгш дараастай ч тохиолдоно.

Харин чулуун дараасны дороос 20-73.5 см гүнд адууны толгой, хүзүү, туурайн яс гардаг. Адууны толгойг тавихдаа хошууг нь наран ургах зүгт хандуулан дөрвөн туурайны хоёрыг нь хошууны баруун, зүүн талд зэрэгцүүлэн тавьж, үлдсэн хоёрыг нь эрүүний углуурга дор нэг нэгээр нь тавьдаг бол хүзүүг нь ихэнхдээ толгойноос салгаж толгойны баруун юмуу зүүн талд тавьсан байдаг (Fitzhugh, Bayarsaikhan, 2003-2008).

2010-2011 онд Хойд Тамирын голын сав нутаг, Баянцагааны хөндийд Монгол-Өвөрбайгалийн хэлбэр төрхийн 1 буган хөшөөний 3 тахилын байгууламжийг (38-р буган хөшөөний 1, 27, 95-р тахилын байгууламж) малтан шинжлэхэд тэдгээрээс хоншоорыг нь зүүн тийш харуулан тавьсан маш муу хадгалалттай адууны толгой, эрүү, хүзүү, туурайн яс зэрэг зүйлс илэрч олдсон (Ерөөл-Эрдэнэ нар, 2010; 2011).

Цагариг хэлбэрийн чулуун дарааст тахилын байгууламж. Энэхүү тахилын байгууламж нь буган хөшөө болон хиргисүүрийн зууван дугуй хэлбэрийн овгор чулуун дарааст тахилын байгууламжийг тойрон байрладаг. Тооны хувьд янз бүр бөгөөд хэдэн арваас эхлэн хэдэн зуугаар тохиолдоно (Ерөөл-Эрдэнэ нар, 2008, 114). Дараасны голч нь дунджаар 62-200 см гаруй ба хүрээ чулууны дундаас 10-20 см гүнд шатсан яс, нүүрсний жижиг үйрмэг хэсгүүд илэрч олддог.

Ийм хэлбэрийн тахилын байгууламжийг Цацын эрэг (13-р буган хөшөөний 1, 28-р тахилын байгууламж), Шивэртийн ам (33-р буган хөшөөний 1, 2, 6, 9, 10, 12-р тахилын байгууламж), Хавцалын ам (40-р буган хөшөөний 4, 14, 27, 28-р тахилын байгууламж), Улаан толгойн ар шил (62-р буган хөшөөний 17-р тахилын байгууламж) зэрэг газруудад 2010-2011 онд малтан судлаж шатсан яс, нүүрсний үлдэгдэл зэргийг илрүүлэн олсон (Ерөөл-Эрдэнэ нар, 2010; 2011).

3.1. Тахилын зан үйлийн учир холбогдол

Аливаа тахилын зан үйл нь тухайн үеийн хүмүүсийн шүтлэг бишрэл, эрхлэх аж ахуй, ертөнцийг үзэх үзэлтэй холбоотой байдаг. Буган хөшөөний дээрх хоёр төрлийн тахилын байгууламжид хоёр өөр хэлбэрээр тахилын зан үйл гүйцэтгэсэн байдаг.

Буган хөшөөний тахилын байгууламжийн гадаад хэлбэрийн ялгаа нь тэдгээрийн тахилын зан үйлийн ялгааг давхар илтгэдэг. Тухайлбал, адууны толгой, хүзүү, туурайгаар тахилга өргөх нь: *Нэгд*, уг адууг хөшөөний эзний хойд насны хүлэг болгох, *Хоёрт*, хөшөөний эзний “сүнс дэгдээх” зан үйл (Пүрэв, 2009, 135)-ийн зориулалттай байж болох юм (Баярсайхан, 2011, 116). Харин шатаасан яс бүхий тахилын байгууламж нь хөшөөний эзэнд

зориулан өргөсөн зоог шүүсийг агуулсан бололтой.

Ер нь буган хөшөө, хиргисүүрийн тахилын байгууламжид адууны толгой, хүзүү, туурай тавих зан үйл хожмын нүүдэлчдэд уламжлагдсаныг судалгааны хэрэглэгдэхүүнээс харж болно. Тухайлбал, Хүннүгийн жирийн иргэдийн булшинд эрэгтэй хүний булшнаас адууны яс хамгийн олон тоогоор олдсон ба ихэнхи тохиолдолд толгой, эрүү, хүзүү, богино хавирга, сүүд, туурай тагалцагны яс, мөн арьс ширээр бүхэл адууг төлөөлүүлэн тавьсан байдаг (Төрбат, 2004, 74-75). Мөн Түрэгийн булш оршуулгаас бүхэл бүтэн адуу, мөн түүний эдлэл хэрэглэл олон тоогоор олддог нь дээрх уламжлалын бас нэг жишээ юм (Монгол ..., 2003).

4. Он цагийн хамаарал

Буган хөшөөг судлаачид хүрэл зэвсгийн сүүд буюу төмөр зэвсгийн түрүү үед хамруулан үздэг боловч нарийвчилсан он цагийн хувьд зөрөөтэй талууд бий.

Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөөдийн холбогдох он цагийг дараах аргаар тогтоож болно. Үүнд:

- Хөшөөн дээр дүрсэлсэн эд зүйлс буюу зэр зэвсгийн дүрслэлээр,
- Тахилын байгууламжаас илэрсэн хэрэглэгдэхүүний C14 буюу цацраг идэвхит нүүрстөрөгчийн үнэмлэхүй он цагаар (Хүснэгт 2),
- Дөрвөлжин булшинд материал болгон ашигласан тохиолдолоор,

2010-2011 онд Хойд Тамирын голын 5 буган хөшөөний хоёр өөр хэлбэр төрхийн нийт 17 тахилын байгууламжийг (цагариган хэлбэрийн 14, битүү чулуун дарааст 3) малтан шинжилж (Хүснэгт-1, Зураг 13-17), тэдгээрээс гарсан адууны толгой болоод шатсан ясны үлдэгдэл, нүүрсний дээжээр C14-ийн судалгаа хийлгэхэд үнэмлэхүй он цагийг НТӨ 1210-760 он хэмээн тогтоосон юм (Хүснэгт-2).

2003-2009 онд Монгол-Америкийн хамтарсан “Буган чулуун хөшөө” төслийн судлаачид Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Улаан толгой, Хөшөөгийн дэвсэг, Хядаг, Хөрт Үзүүр, Галт сумын Нүхтийн ам, Эвт, Хөшөөтийн ам, Цагааннуур сумын Цацгайн хошуу, Шинэ-Идэр сумын Зуны гол, Цохиотын ам зэрэг газрын буган хөшөөний тахилын байгууламжуудыг малтан судлаж, тэдгээрээс гарсан адууны толгой, шатсан ясны дээжээр C14-ийн үнэмлэхүй он цагийг одоогоос 3350-1960 жилийн тэртээд буюу НТӨ 1344-42 хэмээн тогтоосон нь (Fitzhugh, 2009, 5-73, app.2, 219-220) бидний дээрх он цагтай үндсэндээ тохирч байна.

Буган хөшөө нь хиргисүүр, түүний тахилын байгууламжуудтай нэг цаг үеийн дурсгал болох нь улам бүр тодорхой болсоор байна. Тодруулбал, Архангайн Их Тамир сумын Баянцагааны хөндийн адагт орших В10-р хиргисүүрийн холбогдох он цаг НТӨ 1010-110 гэж гарсан (Ерөөл-Эрдэнэ нар, 2012, 53) бол Хануй хөндийн Урт булаг, Баян-Өлгийн Цэнгэл сумын Цагаан гол, Хотон, Сагсай сумын Цагаан асга зэрэг газрын хиргисүүрүүдийн он цагийг НТӨ 1323-457 гэж тогтоосон (Fitzhugh, 2009, 5-73, app. 2, 219-220) мөн Хөвсгөлийн Уушгийн өврийн хиргисүүр, буган хөшөөний тахилын байгууламжуудын он цаг НТӨ 1312-810 (Takahama, 2010, 126-131) хэмээн

гарсан зэрэг нь энэхүү хоёр дурсгал нэг цаг үед бүтээгдэж байсныг батлан харуулж байна.

Дөрвөлжин булшийг үйлдэхэд буган чулуун хөшөөг авч ашигласан тохиолдол бол эл хоёр дурсгалын он цагийн ялгааг харуулах чухал хэрэглэгдэхүүн бөгөөд ийм баримт олон бий. Жишээлбэл, Архангай аймгийн Их Тамир сумын Цац толгойн ар шил (Gantulga et al., 2009, 115-120), Баянцагааны голын адаг, Алтансандал уул, Батцэнгэл сумын Шивэртийн ам, Эрдэнэмандал сумын Хөшөөн тал, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Хядагийн эх, Мөрөн хотын орчим Дэлгэр мөрний хөндий, Галт сумын Нүхтийн ам, Булган аймгийн Орхон сумын төв, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шатар чулуу, Хэнтий аймгийн Дунд Жаргалантын гол зэрэг олон газрын дөрвөлжин булшны өнцөгт буган хөшөөг босгож, мөн булшны хана болгон түүний сийлбэрүүдийг далд ортол булж суулгахаас гадна оршуулгын нүхийг дарж тавих, бүр хэвтүүлэн жирийн материалын хэлбэрээр ашигласан (Цэвээндорж, 1999, 81-85) байгаа нь буган хөшөө дөрвөлжин булшнаас эрт үед холбогдохыг харуулж байна. Мөн ОХУ-ын Тувагийн нутагт, М.И.Грязнов, М.Х.Маннай-Оол нарын малтан шинжилсэн НТӨ VIII-VII зууны үед холбогдох Аржан хэмээх булшны даланг барихад буган хөшөөг жирийн материал болгон ашигласан баримт нь мөн тэдгээр дурсгалын он цагийн ялгааг харуулж байгаа юм.

Буган хөшөөнд бугыг дүрсэлдэгтэй адил амьтныг загварчлан дүрслэх арга барилаар дүрсэлсэн бугын зургууд Архангай аймгийн Их Тамир сумын Хөрөөгийн үзүүр (Дорж, Новгородова, 1975; Ерөөл-Эрдэнэ, Гантулга нар, 2009, 44-49; Magail, 2011, 23-34), Булган аймгийн Орхон сумын Баруун Могой, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Баянхонгор аймгийн Жаргалант сумын Бугат (Цэвээндорж, 1999, 19, 22-25), Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Холбоо толгой (Fitzhugh, 2009, 15) зэрэг олон газраас олдсон нь буган хөшөөний он цагийг урагшлуулан авч үзэх бас нэг чухал баримт юм.

Буган хөшөөний гарал үүслийг судлаачид янз бүрээр тайлбарладаг. Жишээлбэл, Н.Л.Членова бугын дүрс өргөн тархсаныг сак болон түүний төрөл аймгууд эдгээр нутагт нэвтэрч орж ирсний үр дүн мэтээр (Членова, 1962, 34), В.В.Волков буган чулуун хөшөөг үйлдэх зарим арга барил Скифчүүдээс Монголд (Волков, 1981, 71-80), М.Х.Маннай-Оол, Д.Цэвээндорж нар Монголоос Тувад тархсан ба анх Монгол улсын нутагт хүрэл зэвсгийн үед үүсээд цаашид Тува, Байгалийн наад бие нутгаар тархсан (Маннай-Оол, 1970, 302; Цэвээндорж, 1999, 81-85), Д.Эрдэнэбаатар Монголын баруун бүс нутагт анх үүсэн хэлбэр, дүрслэл нь сайжирсаар Алтай-Соёны хэлбэр, түүний дараа Монгол-Байгалийн сонгодог хэлбэр болтлоо хөгжсөн бололтой (Эрдэнэбаатар, 2002, 121) хэмээн үздэг.

Харин бид Монгол нутагт анх үүсээд бусад газар оронд тархсан хэмээх саналыг дэмжиж байгаа төдийгүй анх үүсэн голомт нь Хангайн нурууны зүүн хойд хэсэг бололтой хэмээн үзэж байна.

RÉSUMÉ

J.Gantulga, Ch.Yeruul-Erdene,
J.Magail, Yu.N.Esin

QUELQUES RÉSULTATS RELATIFS A L'ÉTUDE DE PIERRES À CERFS
DANS LA VALLÉE DU KHOIT TAMIR

La mission archéologique conjointe Mongolie-Monaco présente les dernières recherches menées sur les stèles dites "pierres à cerfs" de la Vallée du Khoit Tamir. L'étude de la chaîne opératoire de la confection des stèles a permis de trouver une carrière d'où proviennent les stèles en granite blanc et de formuler des hypothèses sur le transport et la taille des pierres à cerfs. L'expérimentation a donné des résultats intéressants sur les méthodes et les outils utilisés pour graver les iconographies. Les positions primaires des pierres à cerfs et des structures satellites placées autour ont fait l'objet de plusieurs relevés afin de comprendre la chronologie des implantations des dépôts de têtes de chevaux et d'ossements brûlés. Enfin, de nouveaux types de gravures ont été également découverts sur deux stèles de la Vallée du Khoit Tamir.

НОМ ЗҮЙ

Базарсүрэн, 2006 – Базарсүрэн Ж. *Чингис хааны цэргийн зэр зэвсэг*. Улаанбаатар.

Батболд, 2011 – Батболд Н. *Монголын хадны зургийн судалгаа (Говийн бүсийн хэрэглэгдэхүүнээр)*. /Диссертаци/, Улаанбаатар.

Баяр, 1997 - Баяр Д. *Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу*. Улаанбаатар.

Баярсайхан, 2011 - Баярсайхан Ж. *Түрүү үеийн тахилгын байгууламжууд* // Жаргалантын амны буган хөшөөд. Улаанбаатар, т. 112-113.

Волков, 1981 - Волков В.В. *Оленные камни Монголии*. Улан-Батор.

Волков, 2002 - Волков В.В. *Оленные камни Монголии*. Москва.

Дорж, Новгородова, 1975 – Дорж Д., Новгородова Э.А. *Петроглифы Монголии*. Уланбаатор.

Доржсүрэн, 1957 - Доржсүрэн Ц. *1955 онд төв, баруун аймгуудад археологийн шинжилгээ хайгуулын ажил явуулсан тухай* // Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн бүтээл, Улаанбаатар.

Гантулга нар, 2011 – Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Цэнгэл М., Магай Ж. *Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөө*. Улаанбаатар.

Ерөөл-Эрдэнэ нар, 2007 - Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Цэнгэл М., Магай Ж., Милсент П.И., Лодран Ф., Буссиер Ж.Ф. *Цацын эрэг дэх археологийн судалгааны урьдчилсан үр дүнгээс* // *Studia Archaeologica*, Tom. IV, Fasc. 10, Улаанбаатар, т. 131-140.

Ерөөл-Эрдэнэ нар, 2008 - Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Алдармөнх П., Цэнгэл М., Магай Ж., Гризо Ж.Ж., Фабрис Л., Бушиеге Ж.Ф., Рене Д.,

Клауде С., Яник М., Венжамин В., Етиенне Х., Анайс В., Амелие П. *Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2008 оны ажлын тайлан* // Rapport annuel mars 2008 - mars 2009 et projets campagne 2009. Monaco-Ulaanbaatar, pp. 109-133. ШУА-ийн АХГБС.

Ерөөл-Эрдэнэ нар, 2009 - Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Цэнгэл М., Магай Ж., Гризо Ж.Ж., Рене Д., Клауде С., Яник М., Бенжамин В. *Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2009 оны ажлын тайлан*. Улаанбаатар, ШУА-ийн АХГБС.

Ерөөл-Эрдэнэ нар, 2010 - Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Магай Ж., Клауде С. *Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2010 оны ажлын тайлан*. Улаанбаатар, ШУА-ийн АХГБС.

Ерөөл-Эрдэнэ нар, 2011 - Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Магай Ж. *Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2011 оны ажлын тайлан*. Улаанбаатар, ШУА-ийн АХГБС.

Ерөөл-Эрдэнэ нар, 2012 - Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж., Магай Ж. *Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2012 оны ажлын тайлан*. Улаанбаатар, ШУА-ийн АХГБС.

Монгол ..., 2003 - Монгол улсын түүх. Улаанбаатар, I боть.

Монгол хэлний ..., 2008 – Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. А-Г, Улаанбаатар.

Сумъяабаатар, 2005 - Сумъяабаатар Б. *Гучин зургаат тайлбар толь. I-IV*. Улаанбаатар.

Пүрэв, 2009 – Пүрэв О. *Монгол бөөгийн шашин*. Улаанбаатар.

Төрбат, 2004 - Төрбат Ц. *Хүннүгийн жирийн иргэдийн булш*. Улаанбаатар.

Төрбат нар, 2011 – Төрбат Ц., Баярсайхан Ж., Батсүх Д., Баярхүү Н. *Жаргалантын амны буган хөшөөд*. Улаанбаатар.

Цэвээндорж, 1976 - Цэвээндорж Д. *Буган чулуун хөшөө* // ШУА, № 3, Улаанбаатар, т. 32-34.

Цэвээндорж, 1979 - Цэвээндорж Д. *Монгол нутгаас олдсон зарим буган чулуун хөшөөд* // Studia Archaeologica, Tom. VII, Fasc. 13, Улаанбаатар, т. 36-85.

Цэвээндорж, 1999 – Цэвээндорж Д. *Монголын эртний урлагийн түүх*. Улаанбаатар.

Эрдэнэбаатар, 2002 – Эрдэнэбаатар Д. *Монгол нутгийн дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл*. Улаанбаатар.

Бобров, Худяков, 2005 – Бобров Л.А., Худяков Ю.С. *Военное дело сяньбийских государств северного Китая IV-VI вв. н. э.* // Военное дело номадов Центральной Азии в Сяньбийскую эпоху. Сборник научных трудов. Новосибирск. стр. 80-200.

Войтов, 1996 - Войтов В.Е. *Древнетюркский пантеон и модель мироздания. (В культово-поминальных памятниках Монголии VI-VIII вв)*. Москва, стр. 22, 55.

Горелик, 2002 - Горелик М.В. *Армии монголо-татар X—XIV веков*. Москва, 2002.

Кирпичников, 1971 - Кирпичников А.Н. *Древнерусское оружие. Вып. 3*.

Доспех, комплекс боевых средств IX—XIII вв. (САИ. Вып. Е1-36). Ленинград, Наука, 1971.

Крыганов, 1987 - Крыганов А.В. *Кистени салтово-маяцкой культуры Подонья* // Советская Археология. — 1987, № 2.

Кубарев, 1979 - Кубарев В.Д. *Древние изваяния Алтая. Оленные камни.* Новосибирск. Табл. YI, X-3.

Маннай-Оол, 1970 – Маннай-Оол М.Х. *Тува в скифское время.* Москва.

Савинов, 1994 - Савинов Д.Г. *Оленные камни в культуре кочевников Евразии.* СПб., стр. 8-54.

Членова, 1962 – Членова Н.Л. *Об оленных камнях Монголии и Сибири.* Монгольский археологический сборник. Москва.

Эрдэнэ-Очир, 2009 - Н. Эрдэнэ-Очир. *Военное дело древних кочевников Монголии (II тыс. до н.э. – III век до н.э.). /Диссертаци/. Новосибирск.*

Gantulga et al., 2009 - Gantulga J., Grizeaud J.J., Magail J., Tsengel M., Yeruul -Erdene Ch. *Compte rendu de la champagne 2009 de la mission archéologique conjointe Monaco-Mongolie* // Bulletin du Musée d'Anthropologie Préhistorique de Monaco. No.49, Monaco, pp. 115-120.

Granö, 1912 - Granö J. G. *Archaeologische Beobachtungen von meiner reise in Suedsibirien und der ordwest-Mongolei im jahre 1909* // Sonderabdruck aus dem journal de la Societe Finno-Ougrienne XXVIII. Helsingfors, 1912.


Fitzhugh, 2009 - Fitzhugh W. *Mongolia Field Journal 2009* // American-Mongolian Deer Stone Project: Field Report 2009. Washington, D.C., Ulaanbaatar, pp. 5-73.

Jacobson et al., 2001 - Jacobson E., Kubarev V.V., Tseveendorj D. *Repertoire des petroglyphs d'Asie Centrale / Mongolie du Nord-Ouest Tsagaan Salaa / Baga Oigor. (Text et figures).* Tom. V.6, Fasc. 6, De Boccard Paris.


Magail, 2011 – Magail J. *Répertoire des Pierre à Cerfs de la vallée du Haut Tamir* // Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөө. Улаанбаатар, т. 23-33.

Stone, LaRocca, 1999 - George Cameron Stone, Donald J. LaRocca. *A Glossary of the Construction, Decoration and Use of Arms and Armor: in All Countries and in All Times.* — Verlag Courier Dover Publications, 1999. — pp. 228, 230.


Takahama, 2010 - Takahama Shu. *Research of Ulaan Uushig I (Uushgiin Ovor) in Mongolia and newly acquired C14 data* // Древние культуры Монголии и Байкальской Сибири. Барнаул, стр. 126-131.




Зураг 1. Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөө бүхий дурсгалт газрууд




Зураг 2. Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөөдийн одоогийн байршил



Зураг 3. Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөөний өндрийн харьцуулалт




Зураг 4. Хойд Тамирын голын сав нутаг дахь буган хөшөөний дүрслэлийн тоон харьцуулалт




Зураг 5. Хоёр хүн дүрслэгдсэн 87-р буган хөшөө

Хутга					Чинжаал						
24	32	37	40, 53	63	2	8, 40, 78, 90	12	22, 25, 41	5, 29, 56	30	11, 19, 20, 32, 37, 52, 63, 64, 65, 72, 80, 81, 82, 88
					18, 35, 38, 55, 59, 70	21	58	60	43, 64	92	










Зураг 6. Хутга, чинжаал



Зураг 7. Гүйвэр зэвсэг дүрслэгдсэн 41-р буган хөшөө




Зураг 8. Гол модны 20-р бушинаас олдсон хүрэл бөмбөлөг

Дөрвөлжин		Таван талт							
Бамбайн дүрслэл									
Хөшөөний дугаар	2, 30, 35, 70, 83, 85, 93	29	5, 9, 20-22, 31, 33, 34, 37, 40, 43, 49, 54-56, 64, 66, 69, 72, 73, 77, 80, 81	7, 24	26, 32	36, 38	39	63	68

Зураг 9. Бамбайн дүрслэлүүд




Зураг 10. Буган хөшөө хийх туршиц судалгаа ба түүний үр дүн



Зураг 11. Хөрөөгийн үзүүрээс олдсон чулуун багаж




Зураг 12. Архангайн Өндөр-Улаан сумын нутаг
Хануйн хөндийн Жаргалантын амны буган хөшөөний
тахилын цогцолбор (Төрбат нар, 2011, зур. 29)



Зураг 13. Булганы Сайхан сумын нутаг Хайрханы хөндийн буган хөшөөний тахилын цогцолбор (Новгородова, 1989, 220)




Зураг 14. Архангайн Их Тамир сумын нутаг Элстэйн голын амны хашлага чулуу бүхий буган хөшөө




Зураг 15. 13-р буган хөшөөний тахилын цогцолборын дэвсгэр зураг




Зураг 16. 33-р буган хөшөөний цогцолборын дэвсгэр зураг



Зураг 17. 38-р буган хөшөөний тахилын цогцолборын дэвсгэр зураг



Зураг 18. 40-р буган хөшөөний тахилын цогцолборын дэвсгэр зураг



Зураг 19. 62-р буган хөшөөний тахилын цогцолборын дэвсгэр зураг

**Буган хөшөөний тахилын байгууламжуудын
товч мэдээлэл**

Хүснэгт 1

<i>13-р буган хөшөөний тахилын байгууламж</i>					
№	Дараасны хэлбэр	Дараасны голч (см)	Байршил	Гүн (см)	Олдвор хэрэглэгдэхүүн
1	○	170	Хөшөөний урд	10	Шатсан ясны үлдэгдэл
28	○	150	Хөшөөний баруун талд	15.5	Шатсан ясны үлдэгдэл
<i>33-р буган хөшөөний тахилын байгууламж</i>					
1	○	125x130		24	-
2	○	147x150		32	Шатсан ясны үлдэгдэл
6	○	137x140		18-21	Шатсан ясны үлдэгдэл
9	○	180		21	Шатсан ясны үлдэгдэл
10	○	140x170		18	-
12	○	130x138		20	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл
<i>38-р буган хөшөөний тахилын байгууламж</i>					
1	●	310x330	Хөшөөний зүүн талд	42	Адууны толгой, хүзүү
27	●	250	Хөшөөний баруун урд	30	Адууны толгой
95	●	280x286	Хөшөөний хойд талд	73.5	Шатсан ясны үлдэгдэл
<i>40-р буган хөшөөний тахилын байгууламж</i>					
4	○	170	Хөшөөний урд	27-30	Шатсан ясны үлдэгдэл
14	○	151	Хөшөөний баруун урд	20-23	Шатсан ясны үлдэгдэл
27	○	163	Хөшөөний зүүн хойд талд	11	Шатсан яс, нүүрсний үлдэгдэл
28	○	168	Хөшөөний зүүн хойд талд	13-16	Шатсан ясны үлдэгдэл
<i>62-р буган хөшөөний тахилын байгууламж</i>					
4	●	140x158	Хөшөөний зүүн талд	30	-
17	○	147	Хөшөөний баруун урд	24.5	Шатсан ясны үлдэгдэл

○-дүрсээр цагариган хэлбэрийн чулуун дарааст тахилын байгууламжийг , ●-дүрсээр битүү чулуун дараас тахилын байгууламжийг үзүүлсэн болно.

Хүснэгт 2

Буган хөшөөний тахилын байгууламжуудын радиокарбоны он цаг

№	Тахилын байгууламжийн дугаар	Лабораторийн дугаар	Радиокарбоны он цаг	Дээж
1	341	Beta - 290944	НТӨ 1050-890/ НТӨ 870-850	Шатсан яс
2	33. 6	Beta - 323805	НТӨ 1210-1010	Шатсан яс
3	38.1	Beta - 323806	НТӨ 840-800	Адууны яс
4	38.95	Beta - 323808	НТӨ 800-760	Адууны яс